

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
2021 ОНЫ 08 ДУГААР САРД ХЭРЭГЖҮҮЛСЭН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2021 оны 09 дугаар сарын 02

Улаанбаатар хот

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар нь Төрийн албаны тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай хууль, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлийг бууруулах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, Улсын онцгой комисс, Нийслэлийн онцгой комиссын шийдвэрийг баримтлан 2021 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 31-ний өдрийг дуустал дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.1. Виз, зөвшөөрлийн чиглэлээр:

1.1.1. Гадаадын иргэнд үзүүлсэн хувийн урилга, виз, визийн зөвшөөрлийн үйлчилгээ:

Тайлант хугацаанд түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суухаар ирэх хүсэлт гаргасан төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг үндэслэн 1630 гадаадын иргэнд визийн зөвшөөрөл олгосноос 1280 иргэний визийн зөвшөөрлийг Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газарт, 350 иргэний визийн зөвшөөрлийг хилийн боомт, бүсийн газруудад тус тус илгээлээ. *(График 1)*

Түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суухаар ирэх хүсэлт гаргасан төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг үндэслэн 420 гадаадын иргэнд зохих ангилал, зориулалтын Монгол Улсын визийг олгосон байна. *(График 1)*

1.1.2. Гадаадын иргэний бүртгэл, хяналт:

Эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг үндэслэн 470 гадаадын иргэнд Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олгож, 1087 гадаадын иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг сунган, оршин суух зөвшөөрөлтэй 235 гадаадын иргэний бүртгэлд хасалт хийсэн. *(График 1)*


Мөн оршин суугаа хэлбэр нь өөрчлөгдсөн 24 гадаадын иргэнд визийн ангилал солих үйлчилгээ үзүүлж, уригч 27 аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийн дагуу гадаадын 127 иргэний виз, бүртгэлийн талаарх мэдээлэл бүхий тодорхойлолт олгосон.

Монгол Улсад түр ирэгчээр ирсэн 183 гадаадын иргэнийг бүртгэж, нутаг буцсан, статус өөрчлөгдсөн 208 иргэний бүртгэлд хасалт хийж, Монгол Улсад 90 хүртэл хоногийн визтэй ирсэн, мөн визгүй зорчдог түр ирэгч гадаадын иргэнээс тус улсад байх хугацааг сунгуулах хүсэлтийг хянан 92 иргэний визийн хугацааг 30 хүртэл хоногоор сунгаж, гадаадын 10 иргэнд регистрийн дугаар олгов. *(График 1)*

Энэ сарын тоон үзүүлэлтийг 2020 оны 08 дугаар сарын тоон үзүүлэлттэй харьцуулахад визийн зөвшөөрөл олголт 41,6 хувь, виз олголт 46,9 хувь, оршин суух зөвшөөрөл олголт 77,4 хувь, оршин суух зөвшөөрлийн сунгалт 98,0 хувиар тус тус өсөж, оршин суух зөвшөөрлийн хасалт 18,1 хувь, визийн хугацааны 30 хүртэлх хоногийн сунгалт 69,6 хувиар тус тус буурчээ.

Монгол Улсад оршин суух цахим үнэмлэхийг 426 ширхэг шинээр хэвлэн, 593 үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгаж, 9 үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийлээ.

График 1



Гадаадын иргэний Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл, түүний сунгалт, түр ирэгчийн бүртгэл, хасалт, виз, визийн зөвшөөрөл болон холбогдох бусад асуудлаар нийт 2294 иргэн (1800-1882 дугаарын утсаар 1772, биечлэн 159, автомат хариулагчаар 273, имэйлээр 15, фэйсбоок хуудасны чатботоор 75)-д зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан ба код мессеж үйлчилгээг 335 иргэнд илгээсэн.

Тайлант хугацаанд нийт 112 аж ахуйн нэгж, байгууллагын 216 гадаадын иргэний хүсэлтийг цахим (eVisa.mn)-аар хүлээн авснаас 87 аж ахуйн нэгж, байгууллагын 148 гадаадын иргэний хүсэлтийг холбогдох хууль, журмын дагуу хянан шийдвэрлэж, баримт бичгийн бүрдэл хангаагүй бусад аж ахуйн нэгж, байгууллагын гадаадын иргэний хүсэлтийг буцаасан байна.

1.2. Иргэний харьяаллын чиглэлээр:

1.2.1. Монгол Улсын харьяат болох:

Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан 1 иргэн (*Орос Улсын 1*)-ний хүсэлт, баримт бичгийг шинээр хүлээн авсан.

1.2.2. Монгол Улсын харьяатаас гарах:

Монгол Улсын харьяатаас гарч бусад улсын харьяат болох хүсэлт гаргасан нийт 14 иргэн (*Казахстан Улсын 1, Герман Улсын-11, Өмнөд Солонгос Улсын 1, Япон Улсын 1*)-ний хүсэлтийг хүлээн авч, баримт бичгийг холбогдох байгууллагуудад санал авахаар хүргүүлсэн.

Дээрх хугацаанд хоёрдмол харьяалал үүсгэсэн 9 иргэнийг шинээр бүртгэж, бүртгэлийг мэдээллийн санд оруулсан.

08 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар давхардсан тоогоор гадаадын иргэний нэгдсэн бүртгэлийн санд 51 улсын 3871 хоёрдмол харьяалалтай иргэн бүртгэлтэй байна.

Өмнөх оны мөн үед Монгол Улсын харьяат болсон, харьяатаас гарсан болон иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг гараагүй байна.

1.2.4. Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын бүртгэл, хяналт:

Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаатай холбоотой нийт 3 байгууллагын хүсэлт (*үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн 1, зөвшөөрлийн хугацаагаа сунгуулах 2*)-ийг хүлээн авсан.

Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж байгаа нэр бүхий 15 олон улсын болон гадаад улсад төвтэй төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газруудын зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлтийг хянан, холбогдох байгууллагуудад баримт бичгийг хүргүүлж, санал авах ажиллагааг явууллаа.

2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 78 төрийн бус байгууллага бүртгэлтэй байна.

1.2.5. Хүүхэд үрчлэлт:

Тайлант хугацаанд гадаад улсын иргэн, гэр бүлд үрчлэгдсэн нийт 1 хүүхэд (*Америк Улсын 1*)-ийн үрчлэлтийн дараах тайланг хүлээн авч, мэдээллийн санд бүртгэсэн.

Байгууллагын даргын 2021 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн А/151 дүгээр тушаалаар Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах хүсэлт гаргасан гадаадын иргэнтэй ярилцлага хийх комисст өөрчлөлт оруулан баталлаа.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсаас гадаадын иргэн, гэр бүлд нийт 273 хүүхэд үрчлэгдээд байна.

1.3. Зөрчил шалган шийдвэрлэх чиглэлээр:

1.3.1. Гадаадын иргэнд тавих хяналт шалгалт:

Тайлант хугацаанд 2 удаагийн төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 8 аж ахуйн нэгж, байгууллагын 55 гадаадын иргэнийг хамруулахад зөрчил илрээгүй.

Түүнчлэн нийт 20 удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 17 аж ахуйн нэгж, байгууллага, 25 иргэний баримт бичигт үзлэг шалгалт хийснээс, 1 улсын 3 гадаадын иргэн (Вьетнам Улсын 3)-д торгох шийтгэл оногдуулсан байна.


Дээрх хяналт шалгалтын хүрээнд илрүүлсэн 6 улсын 11 гадаадын иргэний гаргасан зөрчилд Зөрчлийн тухай хуулийн дагуу 4,900,000 төгрөг (*Дөрвөн сая есөн зуун мянган*)-ийн шийтгэл оногдуулж, улсын төсөвт төвлөрүүлээ.

1.3.2. Хориг арга хэмжээ:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.2, 37.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн 3 улсын 3 гадаадын иргэн (*Бангладеш Улсын 2, Өмнөд Солонгос Улсын 1, Филиппин Улсын 1*)-ийг байгууллагын даргын 3 удаагийн тушаалаар Монгол Улсаас албадан гаргасан. (*График 2*)

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.3 дахь заалтыг үндэслэн 2 улсын 2 иргэн (*Орос Улсын 1, Хятад Улсын 1*)-ийг байгууллагын даргын 2 удаагийн тушаалаар Монгол Улсаас гарахыг түдгэлзүүллээ. (*График 2*)

График 2



2021 оны 08 дугаар сарын тоон үзүүлэлтийг 2020 оны мөн үетэй харьцуулахад зөрчил гаргасан гадаадын иргэн 26,7 хувь, албадан гаргагдсан гадаадын иргэн 62,5 хувиар тус тус буурч, гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн 100 хувиар өссөн ба зөрчил гаргасан уригч хуулийн этгээд, зөрчил гаргасан уригч иргэн бүртгэгдээгүй байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигаар баталсан “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын дагуу Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэн болон хүн, хуулийн этгээдэд оногдуулсан шийтгэлийн талаарх мэдээллийг 08 дугаар сарын 20-ны өдрийн 01/1133 дугаар албан бичгээр хүргүүлээ.

ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

2.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, хүний нөөц, сургалт, олон нийттэй харилцах чиглэлээр:

2.1.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, төлөвлөгөө, тайлан:

Тайлант хугацаанд Монгол Улсын Засгийн газрын нийт 5 тогтоол, Ерөнхий сайдын 1 захирамжийг бүртгэж, хяналтад авч ажиллав.

Засгийн газрын 192 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Монгол Улсын виз олгох журам”-д заасан “Визийн мэдүүлгийн хуудас”-ны загварын төслийг 08 дугаар сарын 23-ны өдрийн 01/1138, 01/1139 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яаманд тус тус хүргүүлээ.

Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийн 2021 оны эхний хагас жилийн хэрэгжилтийг 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 01/1172 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Байгууллагын 07 дугаар сарын тайланг нэгтгэн боловсруулж, тоон мэдээг инфографик хэлбэрээр 08 дугаар сарын 05-ны өдрийн 01/1073 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, 08 дугаар сарын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 08 дугаар сарын 02-ны өдөр баталлаа.

Түүнчлэн байгууллагын 7 хоног тутмын мэдээг 08 дугаар сарын 02, 09, 16, 23, 30-ны өдрүүдэд тус тус нэгтгэсэн.

Хөвсгөл аймгийн Ханх сумын “Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-нд байгууллагын танилцуулга болон тусгах саналыг 08 дугаар сарын 05-ны өдрийн 01/1074 дүгээр албан бичгээр “Нью Урбанизм” ХХК-д хүргүүлэв.

2.1.2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, хүний нөөц, сургалт:

Дархан Энх Оршихуй сургалтын төвтэй хамтран Англи хэлний ахисан түвшний сургалтыг зохион байгуулж, 10 албан хаагчийг хамрууллаа.

Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газарт визийн асуудал хариуцсан 2 мэргэжилтэн (Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хот, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хөх хотод ажиллах)-нийг мэргэшүүлэх сургалтыг 08 дугаар сарын 10-наас 13-ны өдрийн хооронд зохион байгуулсан.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажилд авах талаар ирүүлсэн чиглэлийн дагуу судалгааг 2021 оны 01/1181 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.

2.1.3. Олон нийт, мэдээ, мэдээлэл:

Тайлант хугацаанд “Монгол Улсын визийн журам шинэчлэгдлээ”, “Монгол Улсын визийн үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоолоо” болон бусад мэдээг давхардсан тоогоор 42 хэвлэл мэдээллийн хэрэгсэл (31 сайт, 5 сонин, 6 телевиз)-ээр сурталчилсан.

Энэ сард байгууллагын цахим хуудаст үйл ажиллагаатай холбоотой 17 мэдээлэл, коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зөвлөмж, зөвлөгөө бүхий 2 зурагт хуудас, үйл ажиллагааны 2 тайлан мэдээг байршуулан, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 2 арга хэмжээний зураг авалтыг хийлээ.

Монгол Улсад Хууль зүй, дотоод хэргийн салбар үүсэж хөгжсөний 110 жилийн ойг тохиолдуулан байгууллагын хамаарах асуудлын хүрээнд олон нийтэд чиглэсэн онцлох ажлын талаар 16 минутын видео контентыг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн чиглэлийн дагуу засварлаж, 08 дугаар сарын 27-ны өдөр цахимаар хүргүүлэв.

08 дугаар сарын 17-ны өдөр daam.mn, tug.mn зэрэг мэдээллийн сайтуудад нийтлэгдсэн “Баянзүрх дүүргийн Аккумуляторийн үйлдвэрт Хятадууд ажиллахаар ирээд нуугдаж байна” гэх мэдээллийн дагуу хяналт шалгалт хийж, мөн сарын 18-ны өдөр хяналт шалгалт хийсэн тухай Tug.mn сайтад тайлбар, мэдээлэл өгөн, олон нийтэд хүргэлээ.

Мөн Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, “Монгол Улсын виз олгох журам”-д тусгагдсан хил орчмын жуулчинд олгох өдрийн визийн талаар 2 минутын видео мэдээлэл (яриа)-ийг Livetv телевизэд, “Монгол Улсын виз олгох журам” хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан журамд оруулсан өөрчлөлтийн онцлог, ач холбогдлын талаар бэлтгэсэн мэдээллийг өдөр тутмын Монголын үнэн сонинд тус тус хүргүүлсэн.

2.2. Хууль, эрх зүй, гадаад харилцааны чиглэлээр:

2.2.1. Хууль, эрх зүй:

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 172 дугаар тушаалаар баталсан “Гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 4.1 дэх хэсэгт өөрчлөлт оруулах тухай саналыг 08 дугаар сарын 31-ний өдрийн 01/1170 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Мөн Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилгын тухай хуулийн төсөлд саналыг 08 дугаар сарын 17-ны өдрийн 01/1116 дугаар албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлээ.

Иргэний нэхэмжлэлтэй Гадаадын иргэн, харьяатын газарт холбогдох захиргааны хэрэгт хариу тайлбар, нотлох баримтыг 08 дугаар сарын 19-ний өдрийн 03/1125 дугаар албан бичгээр Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хүргүүлээ.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт, дагалдан гарсан журмуудын талаар танилцуулга, сургалтыг Монголын аялал жуулчлалын холбоо, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн 40 ажилтанд 08 дугаар сарын 06-ны өдөр цахим хэлбэрээр, Хилийн цэргийн 0218 дугаар ангийн Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудалд үүрэг гүйцэтгэдэг 140 алба хаагчдад мөн сарын 10, 11-ний өдрүүдэд танхимаар зохион байгуулсан.

2.2.2. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа:

Тайлант хугацаанд Америкийн Нэгдсэн Улсын Төрийн департаментын дотоод бүтэцтэй танилцах судалгааны ажил хийлээ.

08 дугаар сарын 13-ны өдөр байгууллагын дарга Н.Ууганбаяр Америкийн Нэгдсэн Улсын ЭСЯ-ны Бүс нутгийн аюулгүй байдлын атташе, 08 дугаар сарын 30-ны Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас Монгол Улсад суугаа ЭСЯ-ны Хоёрдугаар нарийн бичгийн дарга зэрэг хүмүүсийг тус тус хүлээн авч, хамтын ажиллагааны талаар санал солилцов.

Мөн 08 дугаар сарын 16-ны өдөр НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд байгуулж буй “Хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны үзэл баримтлал”-ын баримт бичгийг батлах ёслол, хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа.

К3 ангиллын визийн мэдүүлгийн хуудсыг монгол-англи хэлнээ, визийн мэдүүлгийн хуудсыг англи хэлнээ, тэмдэгтийн хураамжид орсон холбогдох заалтуудыг англи, орос, хятад, солонгос хэлнээ тус тус орчуулсан.

Бусад орны ижил чиг үүргийн байгууллагуудад өрнөж буй мэдээ, мэдээллийг “7 хоногийн тойм” нэрээр бэлтгэн Хууль зүй, дотоод хэргийн яаманд хэвлэмэл болон цахим хэлбэрээр долоо хоног тутам хүргүүлэн ажиллаж байна.

2.3. Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрүүл аюулгүй байдлын чиглэлээр:

Байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэдийн халууныг үзэх, бүртгэл хөтлөхөд хяналт тавин, халдвар хамгааллын дэглэм сахих, сэжигтэй тохиолдол илэрсэн үед авах арга хэмжээний талаар зөвлөмж, мэдээллээр ханган ажиллаж, Хууль зүй дотоод хэргийн яамны shtab@mojha.gov.mn цахим хаягт коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын халдварын мэдээг өдөр бүр тогтмол хүргүүлж байна.

2.4. Архив, албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлын чиглэлээр:

2.4.1. Архив, албан хэрэг хөтлөлт:

Монгол Улсын иргэний харьяалалтай холбогдох 9 хадгаламжийн нэгжийн 1885 хуудас баримтыг цахим хэлбэрт шилжүүлэн архивын нэгж үүсгэлээ.

Тайлант хугацаанд байгууллагын даргаас А тушаал 13, Б тушаал 19 буюу нийт 32 тушаал баталсныг цахим хэлбэрт шилжүүлж, архив албан хэрэг хөтлөлтийн программд оруулан, хариуцсан албан хаагчдаар үүргийн биелэлтийг хангуулан ажиллаж байна.

Байгууллагад ирүүлсэн нийт 205 албан бичиг (*харуутай 73*)-ийг хүлээн авч, холбогдох албан тушаалтанд шилжүүлэн, нийт 152 албан бичгийг гадагш илгээсэн

ба хяналтад 19 албан бичиг байна. Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн албан бичиг байхгүй.

2.4.2. Өргөдөл, гомдол:

2021 оны 08 дугаар сард аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, албан хаагчдаас нийт 32 өргөдөл ирүүлснийг хүлээн авч, 27 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэн, 5 өргөдөл шийдвэрлэлтийн шатанд хянагдаж байна. Хуулийн хугацааг сунгасан болон хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн өргөдөл байхгүй.

2.5. Мэдээллийн технологийн чиглэлээр:

2.5.1. Программ хангамж:

Хүүхэд үрчлэлтийн САО програмын серверийг бэлтгэж, 08 дугаар сарын 11-ний өдөр, үйлчилгээний хариуг гар мессежээр хүргүүлэх SMS Pro системд олон дугаарт нэг мессежийг явуулах боломжит өөрчлөлтийг хийж, 08 дугаар сарын 26-ны өдөр, цахим архивын программд баримт устгах хэсгийг шинээр нээж, мөн өдөр тус тус ажиллагаанд оруулав.

“Монгол Улсын виз олгох журам” шинэчлэн батлагдсантай холбогдуулан ISM системд визийн ангилал, тэмдэгтийн хураамжтай холбоотой шинэчлэлтийг хийж, 08 дугаар сарын 31-ний өдөр ажиллагаанд нэвтрүүлэн, тайлант хугацаанд мэдээлэл засварлах маягтын дагуу 3 удаагийн засвар оруулж бэлтгэсэн.

NetFlow программаар сүлжээний хяналт, мониторингийг тогтмол хийх зорилгоор виртуал серверийг бэлтгэж, программ хангамжийг суулган 08 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн бүрэн ажиллагаанд орууллаа.

2.6. Санхүү, хөрөнгө оруулалт, хангамжийн чиглэлээр:

2.6.1. Төсвийн хөрөнгийн зарцуулалт:

2021 оны 08 дугаар сард өссөн дүнгээр 2,433.7 сая төгрөгийн санхүүжилт авч, 2,275.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллан, батлагдсан төсвийг зориулалтын дагуу өр, авлагагүй, хэмнэлттэйгээр, зохих журамд нийцүүлэн анхан шатны баримтыг үндэслэн зарцуулсан.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 09 дүгээр сарын батлагдсан төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай саналыг 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 01/1135 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төслийг Сангийн яамны төсвийн FISCAL программд оруулж, Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газарт нэгтгүүллээ.

Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суугаа ЭСЯ-д 44512,5 ам доллар буюу 126,887,685.75 төгрөг, Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хөх хотод суугаа Ерөнхий консулын газарт 32700,0 ам доллар буюу 93,230,802 төгрөг, нийт 220,118,487.75 төгрөгийг дээрх газруудад томилогдсон виз,

зөвшөөрлийн асуудал хариуцсан албан хаагчдын холбогдох зардалд зориулан цалингийн хэмнэлтийн зардлаас шилжүүлсэн.

2.6.2. Орлого төвлөрүүлэлт:

2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар өссөн дүнгээр 558.0 сая төгрөгийн улсын тэмдэгтийн хураамж, 9.4 сая төгрөгийн хүү, торгуулийн орлого төвлөрүүлж, Хан-Уул дүүргийн татварын орлогын дансанд шилжүүлсэн байна.

2.6.3. Хөрөнгө оруулалт, худалдан авалт, хангалт:

Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 2020 оны биелэлтийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэв.

2.7. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын чиглэлээр:

2.7.1. Хяналт-шинжилгээ:

Байгууллагын 07 дугаар сарын үйл ажиллагааны тайланг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Монгол Улсын Ерөнхий сайдын ахлах зөвлөх болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 01/1077, 01/1078, 01/1079 дүгээр, гадаадын иргэдийн бүртгэл, хяналтын 07 дугаар сарын мэдээг Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газарт 01/1076 дугаар албан бичгээр тус тус хүргүүлж ажиллав.

Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлд хамтран ажиллах, мэдээлэл солилцох үүрэг бүхий албан тушаалтны мэдээллийг 08 дугаар сарын 05-ны өдрийн 01/1081 дүгээр албан бичгээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд мөн хүргүүлээ.

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны мэдээг 08 дугаар сард Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт нийт 22 удаа цахимаар хүргүүлсэн.

2.7.2. Аудит, нийцлийн чиглэлээр:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд байгууллагын цахим хуудаст байршуулсан 2021 оны 07 дугаар сарын тоон мэдээлэлд хяналт тавьж ажиллалаа.

2.8. Хилийн боомт, орон нутгийн чиглэлээр:

Байгууллагын даргын “Хууль тогтоомжийн сургалт, сурталчилгааны ажлын зохион байгуулалтын тухай” 2021 оны А/96 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд шинэчлэн батлагдсан Гадаадын иргэний, эрх зүйн байдлын тухай хуулийн өөрчлөлт, холбогдох журмыг танилцуулах зорилгоор зохион байгуулсан 3 удаагийн сургалтад давхардсан тоогоор орон нутаг дахь нэгжийн 78 албан хаагч хамрагджээ.

Мөн орон нутаг дахь нэгжүүд 2021 оны сургалтын төлөвлөгөөний дагуу Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, холбогдох журмуудыг албан хаагчид болон хамтын ажиллагаатай бусад байгууллагын албан хаагчдад танилцуулах, Үндэсний бичгийн, Хятад хэл болон Англи хэлний урт хугацааны зэрэг нийт 4 удаагийн сургалтыг дотооддоо зохион байгуулж ажилласан байна.

Баруун бүс дэх газар, Баян-Өлгий аймаг дахь хэлтэс нь албаны байр барих барилгын асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох баримт бичгийг барилгын зураг төслийг гүйцэтгэгч компани болон Хууль зүй, дотоод хэргийн яамнаас томилогдсон ажлын хэсэгт тухай бүр хүргүүлэн ажилласан.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар баригдаж байгаа Замын-Үүд боомтын цогцолборын барилгын ажлын явц 08 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зорчигчийн хэсэг 50 хувьтай, ачаа тээврийн хэсэг 42 хувьтай байгаа бөгөөд боомтын барилгын ажилд оролцож байгаа Хятад Улсын 91 иргэнд хяналт тавьж байна.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Сэлэнгэ аймагт байрлах Сүхбаатар хилийн боомтод баригдах хилийн хяналтын байгууллагуудын нэг цэгийн 6 давхар үйлчилгээний цогцолборын барилгын ажлын явцын гүйцэтгэл 65 хувьтай байна. Мөн Сангийн яам, Гаалийн ерөнхий газар, Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр "Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл"-ийг хэрэгжүүлэх төслийн хүрээнд Алтанбулаг хилийн боомтын барилга байгууламжийн өргөтгөл, шинэчлэлийн барилга угсралтын ажил хийгдэж байна.